


ХАСБАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ ТАЙЛАН

Б.Уламбаяр
2023 оны 3 дугаар улирал



МЭДЭГДЭЛ

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн Хараат бус гишүүн Б.Уламбаяр миний бие: (i) Компанийн тухай хууль ("КтХ"), Банкны тухай хууль ("БтХ"); (ii) Монголбанкны холбогдох журмууд болох "Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журам" ("Засаглалын хяналт шалгалтын журам"), "Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам" ("Хараат бус гишүүний журам"); (iii) ХасБанкны Дүрэм болон бусад холбогдох засаглалын бодлого, зарчмын дагуу энэхүү Хараат бус гишүүний тайлан ("Тайлан")-г бэлтгэсэн болно.

Тайлан нь дараах хугацааг хамарна: [2023 оны 3 дугаар улирал] ("Тайлант хугацаа").

1. ОРОЛЦООНЫ ТАЙЛАГНАЛ

(Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.1 болон 5.2.2 дахь заалт)



Тайлант хугацаанд Хүснэгт 1-д заасан дараах хурлуудад оролцож ажиллалаа. Мөн хуралд оролцсон ажлын тайлангуудыг тус бүр 7 дугаар сарын 31, 8 дугаар сарын 15 болон 9 дүгээр сарын 25-ны өдөр тус бүр тайлагнаж, Монголбанкинд хүргүүлж ажилласан.

Тайлант хугацаан дахь ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх Хороодын хурлууд Хүснэгт 1

Хурлууд	Оролцсон байдал	Огноо
ТУЗ-ийн хурал	Хараат бус гишүүнээр	<ul style="list-style-type: none"> 2023 оны 7 дугаар сарын 07 2023 оны 7 дугаар сарын 20-ны өдрөөс 8 дугаар сарын 04 2023 оны 8 дугаар сарын 02 2023 оны 9 дүгээр сарын 28
ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны хурал ("АХ")	Хорооны даргаар	<ul style="list-style-type: none"> 2023 оны 7 дугаар сарын 06 2023 оны 9 дүгээр сарын 28
ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны хурал ("ЭУХ")	Хорооны гишүүнээр	<ul style="list-style-type: none"> 2023 оны 7 дугаар сарын 06 2023 оны 9 дүгээр сарын 28
ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшуулын хорооны хурал ("ЗНДЦУХ")	Хорооны гишүүнээр	<ul style="list-style-type: none"> 2023 оны 7 дугаар сарын 06 2023 оны 8 дугаар сарын 02 2023 оны 8 дугаар сарын 18 2023 оны 9 дүгээр сарын 04 2023 оны 9 дүгээр сарын 28
Хувьцаа эзэмшигчдийн хурал	Хараат бус гишүүнээр	<ul style="list-style-type: none"> 2023 оны 9 дүгээр сарын 15

1.1 ТУЗ-ИЙН ХУРЛУУД

- ТУЗ-ийн ээлжит хурал 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр дараах асуудлуудыг хэлэлцэж, хуралдав. Үүнд:

- 1 ТУЗ-ийн өмнөх шийдвэр, зөвлөмжийн талаарх явцын мэдээлэл
- 2 ТУЗ-ийн дэргэдэх Хороодын тайлан:
 - 2.1 ЗНДЦУХ
 - 2.2 АХ
 - 2.3 ЭУХ
- 3 ХасБанкны нийтэд гаргасан хувьцааны талаарх явцын мэдээлэл
- 4 Мэдээллийн ил тод байдлын журам
- 5 ТУЗ-ийн гишүүд болон ажилтнуудын ёс зүйн кодекс ба сонирхлын зөрчлийн ерөнхий журам
- 6 Шүгэл үлээх бодлого (шинэ)
- 7 Авлига, хээл хахуулийн эсрэг ерөнхий журам (шинэ)
- 8 Дотоод мэдээлэл эзэмшигчийн арилжааны ерөнхий журам (шинэ)
- 9 Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хэлцэл хийх журам (нэмэлт өөрчлөлт)
- 10 ТУЗ-ийн гишүүн болон Гүйцэтгэх удирдлагын даатгалын тухай явцын мэдээлэл
- 11 Нийтэд гаргасан хувьцааны орлого: ХасБанк ХК-ийн дүрэмд тусгах (зөвхөн хувь нийлүүлсэн хөрөнгө)
- 12 
- 13 Удирдлагын тайлан: (2023 оны 5 дугаар сар)
 - Эдийн засаг, банкны салбарын тайлан
 - Бизнесийн гүйцэтгэл
 - Санхүүгийн үр дүн ба цэвэр хүүгийн маржин
- 14 Мэдээллийн технологи & Цахим банкны талаарх явцын мэдээлэл
- 15 

Хэлэлцсэн асуудал #5: ТУЗ-ийн гишүүд болон ажилтнуудын ёс зүйн кодекс ба сонирхлын зөрчлийн ерөнхий журмын 2.5.8-д саналаа хэлж тусгуулсан.

Хэлэлцсэн асуудал #13: Цэвэр хүүгийн маржины анализ дээр, доллар болон төгрөгийн хадгаламжийн хүүгийн бууралт болон харилцах дансны хүүгийн бууралтын зохицуулалт, авсан арга хэмжээ нь эцсийн маржинд ямар ялгаатай нөлөөлсөн талаар лавлаж, хэлэлцүүлэг өрнүүлсэн. Санхүү хариуцсан дэд захирлын зүгээс анализаа шинэчилж хүргүүлэхээр болсон.

Хэлэлцсэн асуудал #2, #4, #5, #6, #7, #8, #9 болон #11 ТУЗ-ийн гишүүд баталсан. Миний зүгээс эдгээр шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд зөрүүтэй байр суурь байгаагүй.

Хэлэлцэх асуудал #12 батлах түвшинд хүрээгүй байгаа тул хэлэлцээгүй болно.

Хэлэлцсэн асуудал #15: Ихэнх гишүүд ерөнхийдөө ижил байр суурьтайгаар саналаа солилцож, шийдвэрлэсэн. ТУЗ-ийн ихэнх гишүүд татгалзсан санал өгсөн бол миний зүгээс түдгэлзсэн санал өгсөн.

- ТУЗ-ийн ээлжит хурал 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр дараах асуудлуудыг хэлэлцэж, хуралдав. Үүнд:

- 1 ТУЗ-ийн өмнөх шийдвэр, зөвлөмжийн талаарх явцын мэдээлэл
- 2 ТУЗ-ийн дэргэдэх Хороодын тайлан:
 - 2.1 ЗНДЦУХ
 - 2.2 АХ
 - 2.3 ЭУХ
- 3 Удирдлагын тайлан: (2023 оны 8 дугаар сар)
Эдийн засаг, банкны салбарын тайлан
Бизнесийн гүйцэтгэл
Санхүүгийн үр дүн
- 4
- 5
- 6
- 7

Хэлэлцсэн асуудал #3: Системийн банкууд дунд ХасБанк хамгийн бага хүүтэй энэ үед банкны хадгаламжийн хүүг ойрын хугацаанд өөрчилж, шинэчлэх шаардлагатай эсэхийг асуусан.

- **ТУЗ-ийн ээлжит бус хурал** 2023 оны 8 дугаар сарын 02-ны өдөр дараах асуудлуудыг хэлэлцэж, хуралдав. Үүнд:
 - 1 ТСН-ийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн ээлжит бус хурлаас гарсан шийдвэрийн талаарх явцын мэдээлэл; мөн
 - 2 ХасБанк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2023 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр зарлан хуралдуулах тухай.

Дээрх асуудлууд ТУЗ-аар батлагдсан. Би эдгээр шийдвэрийг дэмжсэн бөгөөд зөрүүтэй байр суурь байгаагүй.

- Мөн түүнчлэн Хүснэгт 2-т заасан дараах ТУЗ-ийн цахим санал хураалтын хуралд оролцсон.

Тайлант хугацаан дахь ТУЗ-ийн цахим санал хураалтын хурлууд

Хүснэгт 2

Хурал	Санал хураалт	Огноо
ТУЗ-ийн цахим санал хураалтын хурал	ТУЗ-ийн 2023-2024 оны хурлын хуваарь батлах тухай	2023 оны 7 дугаар сарын 20-ны өдрөөс 8 дугаар сарын 04

Дээрх асуудлууд ТУЗ-аар батлагдсан. Би эдгээр шийдвэрийг дэмжсэн бөгөөд олонхитой санал нийлээгүй зүйл байгаагүй.

1.2 ТУЗ-ийн ДЭРГЭДЭХ АУДИТЫН ХОРООНЫ ХУРАЛ ("АХ")

Хүснэгт 3-т завсан дараах АХ-ны хурлуудад оролцсон.

Тайлант хугацаан дахь АХ-ны хурлууд

Хүснэгт3

Огноо	Хэлэлцсэн асуудал
2023 оны 7 дугаар сарын 06	1. Аудитын тайлан 1.1 Санхүүгийн түрээс (leasing)-ийн үйл ажиллагаа 1.2 Компанийн Засаглал 1.3 Мэдээллийн технологийн өөрчлөлтийн менежмент 2. Аудитын зөвлөмжийн талаарх явцын мэдээлэл (шинэчилсэн) 3. Дотоод аудитын дүрэм болон баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах 4. Банкны холбогдох этгээдүүдийн хагас жилийн тайлан (МонголБанкны журам)
2023 оны 9 дүгээр сарын 28	1. Аудитын хорооны даргыг сонгох тухай 2. Эрнст энд Янг Монголия Аудит ХХК-ийн хийсэн хагас жилийн тайлан 3. Аудитын тайлан 3.1 Орон нутгийн салбар 3.2 Мэдээллийн технологийн хөрөнгийн удирдлага 3.3 Үргэлжилсэн аудит 3.4 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тайлан 3.5 Тусгай активын газар 4. Банкны холбогдох этгээдүүдийн улирлын тайлан (МонголБанкны журам)

• 2023 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн хурал

- ТУЗ-ийн АХ-ны хурлыг тус хорооны даргын хувьд миний бие удирдаж явуулсан. Хурлын өмнө, зарим асуудлуудын талаар Ерөнхий аудитортой уулзаж, зөвлөлдсөн.
- Хэлэлцсэн асуудал #4: Зарим ТУЗ-ийн гишүүдийн холбогдох этгээдүүдийн мэдээлэл бүрэн бус эсвэл тодорхойгүй байгаа тул, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын зүгээс дахин холбогдож бүрэлдүүлэхээр болсон.

- Хэлэлцсэн асуудал #3: Хорооны гишүүд санал нэгтгэйгээр баталж, ТУЗ-ийн хурлаар батлуулахаар оруулсан.
- Миний зүгээс хурлын дээрх шийдвэрийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.

• 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн хурал

- Хэлэлцсэн асуудал #1: Гишүүд намайг хорооны даргаар нэр дэвшүүлж, санал хураалтаар би АХ-ны даргаар сонгогдсон.
- АХ-ны даргын хувьд тус АХ-ны хурлыг удирдсан.
- Хэлэлцсэн асуудал #2: Тайланг АХ-ны гишүүд санал нэгтгэйгээр баталж, ТУЗ-ийн хурлаар батлуулахаар оруулсан.
- Миний зүгээс хурлын дээрх шийдвэр, зөвлөмжийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.

1.3 ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРООНЫ ХУРАЛ ("ЭУХ")

Хүснэгт 4-т заасан дараах ЭУХ-ны хурлуудад оролцсон.

Тайланг хугацаан дахь ЭУХ-ны хурлууд

Хүснэгт4

Огноо	Хэлэлцсэн асуудал
2023 оны 7 дугаар сарын 06	<ol style="list-style-type: none"> 1. 2023 оны 5 дугаар сарын байдлаарх эрсдэлийн тайлан 2. ХасБанкны удирдлагын зээлийн зөвшөөрөл олгох эрхийг нэмэгдүүлэх хүсэлтийг ТУЗ-д хүргүүлэх 3. Мөнгө угаахтай тэмцэх журам ("AML") (шинэ) 4. Харилцагчийг таньж мэдэх журам ("KYC") (шинэ) 5. 2023 оны 5 дугаар сарын байдлаарх хянан нийцүүлэлтийн явцын мэдээлэл 6. 2023 оны 2 дугаар улирлын холбогдох этгээд /сонирхлын зөрчлийн хэлцлийг соёрхон батлах
2023 оны 9 дүгээр сарын 28	<ol style="list-style-type: none"> 1. ЭУХ-ны хурлын даргыг сонгох тухай 2. 2023 оны 8 дугаар сарын байдлаарх эрсдэлийн тайлан 3. Авлига, хээл хахуулийн эсрэг ерөнхий журмын шинэчлэл 4. 2023 оны 8 дугаар сарын байдлаарх хянан нийцүүлэлтийн явцын мэдээлэл 5. 2023 оны 3 дугаар улирлын холбогдох этгээд /сонирхлын зөрчлийн хэлцлийг соёрхон батлах

• 2023 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн хурал

- Хэлэлцсэн асуудал #1: ОХУ-Украин нөхцөл байдлын нөлөөнд автсан чанаргүй зээлийн хувьд, миний зүгээс зээлдэгчийн бизнесийн онцлог, салбар зэргийн талаар тодруулга авсан.
- Хэлэлцсэн асуудал #2: цаашид шийдэгдэх өндөр дүнтэй зээлийн хүсэлтийн хувьд, Банкны шинэ харилцагчийн анхны зээл байх магадлал болон эрсдэл талаас саналаа хэлж, хэлэлцүүлсэн.
- Хэлэлцсэн асуудал #2, #3, #4 болон #6-г Хорооны гишүүд санал нэгтэй баталсан.

- o Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.

• 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн хурал

- o Хэлэлцсэн асуудал #3 болон #5-ыг Хорооны гишүүд санал нэгтгэйгээр баталж, ТУЗ-ийн хурлаар батлуулахаар зөвлөмжийг гаргасан.
- o Миний зүгээс хурлын дээрх шийдвэр, зөвлөмжийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.

1.4 ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ЗАСАГЛАЛ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, ЦАЛИН УРАМШУУЛЫН ХОРООНЫ ХУРАЛ ("ЗНДЦУХ")

Хүснэгт 5-т заасан дараах ЗНДЦУХ-ны хурлуудад оролцсон.

Тайлант хугацаан дахь ЗНДЦУХ-ны хурлууд

Хүснэгт 5

Огноо	Хэлэлцсэн асуудал
2023 оны 7 дугаар сарын 06	<ol style="list-style-type: none"> 1. Өмнөх ЗНДЦУХ-ны хурлын ТУЗ-ийн гишүүдийн үнэлгээний тухай санал хүсэлт: 3 асуултын эргэн хяналт (аман байдлаар мэдээлсэн) 2. ХасБанкны Хараат бус гишүүний 1 сул орон тооны сонгон шалгаруулалтын талаарх явцын мэдээлэл (аман байдлаар мэдээлсэн) 3. ХасБанк ХК-ийн ТУЗ-д ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлэх тухай 4. Компанийн тухай хууль, Банкны тухай хуулийг дагаж мөрдөхтэй холбоотой ТУЗ-ийн хороодын бүрэлдэхүүн 5. ТУЗ-ийн цалин хөлс болон нөхөн төлбөрийн ерөнхий журам (нэмэлт өөрчлөлт) 6. Ажилтны зээлийн ерөнхий журам (нэмэлт өөрчлөлт) 7. Ажилчдын зээлийн нөхцөлийн эргэн хяналт (жилээр) 8. ХасБанкны засаглалын кодекс (нэмэлт өөрчлөлт) 9. Санхүүгийн зохицуулах хорооны компанийн засаглалын кодексийн дагуух компанийн засаглалын төлөвлөгөө (2023-2025) 10. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам 11. ЗНДЦУХ-ны Дүрэм 12. ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх ерөнхий журам 13. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журам (шинэ) 14. ТУЗ-ийн гишүүдийн гэрээний загвар 15. _____ 16. Урт хугацааны урамшууллын төлөвлөгөө (LTIP)
2023 оны 8 дугаар сарын 02 (ээлжит бус)	<ol style="list-style-type: none"> 1. ХасБанкны Хараат бус гишүүний 1 сул орон тооны сонгон шалгаруулалтын талаарх явцын мэдээлэл

Хараат бус гишүүний тайлан

2023 оны 8 дугаар сарын 18 (ээлжит бус)	1. ХасБанкны Хараат бус гишүүний 1 сул орон тооны сонгон шалгаруулалтын талаарх явцын мэдээлэл
2023 оны 9 дүгээр сарын 04 (ээлжит бус)	1. ХасБанкны Хараат бус гишүүний 1 сул орон тооны сонгон шалгаруулалтын талаарх явцын мэдээлэл
2023 оны 9 дүгээр сарын 28	<ol style="list-style-type: none"> 1. ЗНДЦУХ-ны даргыг сонгох тухай 2. Монголбанкны зохистой засаглалын үнэлгээний тайлан 3. ХасБанкны Хараат бус гишүүний 1 сул орон тооны сонгон шалгаруулалтын талаарх явцын мэдээлэл 4. Хувьцааны үнэд суурилсан урамшууллын хөтөлбөр (PSP) болон Урт хугацааны урамшууллын төлөвлөгөө (LTIP)-д дүн шинжилгээ хийх ажлын хэсгийн явцын мэдээлэл 5. ЭУХ-ны гишүүнчлэл

• 2023 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн хурал

- Тус хорооны хуралд ажиглагчаар оролцсон.
- Хэлэлцсэн асуудал #4: ТУЗ-ийн хороодын бүтэц дээр, холбогдох хуулийн дагуу хорооны гишүүдийн 2/3 нь хараат бус гишүүн байх шаардлага байгаа тул, цаашид хараат бус гишүүдийн тоог одоогийн 3-4 ч биш, 5-6 болгож нэмэх нь зохистой байж магадгүй талаар саналаа хэлсэн.
- Хэлэлцсэн асуудал #10: ТУЗ-ийн дотоод журам дээр, ТУЗ-ийн гишүүний Банкнаас бусад байгууллага дээрх ТУЗ-ийн гишүүний томилгооны зохицуулалтын тухайд, саналаа нэмэрлэж хэлэлцүүлэгт оролцсон.
- Хэлэлцсэн асуудал #10: ТУЗ-ийн дотоод журам дээр, ТУЗ-ийн хороодын гишүүдийн тоо 5-аас доошгүй байна гэсэн заалтын хувьд, хорооны гишүүдийн 2/3 нь хараат бус гишүүн байх шаардлага байгаа тул дээрх 5 гэсэн тоог багасгавал зохистой байж магадгүй талаар саналаа хэлсэн.
- Хэлэлцсэн асуудал #11: Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны дотоод журам дээр, ТУЗ-ийн гишүүний Банкнаас бусад байгууллага дээрх ТУЗ-ийн гишүүний томилгооны зохицуулалтын тухайд, саналаа хэлсэн.
- Хэлэлцсэн асуудал #13: Хувь нийлүүлэгчдийн хурлыг зохион байгуулах дотоод журам дээр, хурлыг явуулах хэлийг Монгол эсвэл англи эсвэл хос байх эсэх, мөн журам зохицуулалтанд энэ талаар тухайлан тусгах эсэх тухайд, саналаа хэлж хэлэлцүүлэг өрнүүлсэн.
- Хэлэлцсэн асуудал #14: ТУЗ-ийн гишүүний гэрээ дээр, гэрээ дууссаны дараа тодорхой үйл ажиллагааг явуулахгүй байх "Хязгаарлалттай хугацаа"-ны зохистой уртын талаар өөрийн саналыг хэлсэн.

• 2023 оны 8 дугаар сарын 02, 8 дугаар сарын 18 болон 9 дүгээр сарын 04-ний өдрийн хурлууд

- Миний зүгээс Хараат бус гишүүний 1 сул орон тоонд шалгарсан нэр дэвшигч бүрт өөрийн үнэлгээ, саналыг өгсөн.

• 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн хурал

- Тус өдрийн Хорооны хуралд гишүүнээр оролцсон.

2. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ БА ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЛИЙН ТАЙЛАН**(БтХ-ийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг болон Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.3 дахь заалт)**

БтХ-ийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэгт Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн нь сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлахад заавал оролцож, санал өгнө гэж заасан.

Тайлант хугацаанд, ТУЗ-ийн 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн хурлаар 12 сонирхлын зөрчилтэй хэлцэл, мөн ТУЗ-ийн 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн хурлаар 3 сонирхлын зөрчилтэй хэлцэл, нийт 15 (арван тав) сонирхлын зөрчилтэй хэлцлийг баталсан. Эдгээр бүх хэлцэлд оролцож, саналаа өгч ажилласан.

ТУЗ-ийн гишүүдээс сонирхлын зөрчилтэй гишүүн байсан тохиолдолд тухайн гишүүн нь хурлын эхэнд ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ мэдэгдэж, хэлэлцсэн асуудалд санал өгөөгүй болохыг тэмдэглэж байна.

3. ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАН**(КтХ-ийн 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсэг, Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.4 дахь заалт болон Засаглалын хяналт шалгалтын журмын 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэг)**

Дээр дурдсан хууль тогтоомжоор Хараат бус гишүүн нь Банкны оролцогч талууд, түүний дотор Хувьцаа эзэмшигч, харилцагч, хадгаламж эзэмшигч болон банкны ажилтны эрх ашгийг хамгаалах үүднээс ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь Банкны эрх ашиг, сонирхолд нийцсэн эсэх, мөн үйл ажиллагаа нь хууль тогтоомж дүрэм журамд нийцсэн эсэхэд хяналт тавих эрхтэй.

Банкны засаглалыг дүгнэхэд:

КтХ-ийн 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсэгт заасан арга хэмжээ

КтХ 79.3.1 болон Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.5	Уг заалтын дагуу, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хяналтыг тавьж, хуралд оролцож, саналаа өгсөн. Тайлангийн хугацаанд, ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого шийдвэрүүд нь уг заалтад тодорхойлогдохуйц сөргөөр нөлөөлсөн зүйл ажиглагдаагүй болно.
(БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ, ЖУРМЫН НИЙЦЭЛ)	Энэ талаар, тайлан дахь оролцсон хурал тус бүрийн тайлбарт шаардлагатай бол тэмдэглэсэн.
КтХ 79.3.2	Уг заалтын хүрээнд, удирдлага нь ил тод, нээлттэй байдлыг үргэлжлүүлэн хэвийн хангаж ажиллаж байгаа бөгөөд, тусгайлан үүрэг өгч ажиллахаар нөхцөл байдал үүсээгүй болно.

(БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ)	
КтХ 79.3.3 (ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ)	2023 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд биечлэн оролцсон ба хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн асуултад хариулах, тодруулга хийхэд бэлэн байсан. Хурлаар хэлэлцсэн асуудалд зарчмын зөрүүтэй байр суурь байгаагүй болно.
Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.1 (ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ГАРГАСАН ШИЙДВЭР НЬ БАНКНЫ ЭРХ АШИГТ НИЙЦСЭН ЭСЭХ)	Банкны засаглал хэвийн сайн хэрэгжиж байна. ТУЗ ба удирдлагын багийн зүгээс, Банкны эрх ашигт сөргөөр нөлөөлөх үйлдэл, шийдвэр ажиглагдаагүй.
Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.2 (ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦСЭН ЭСЭХ)	Хувьцаа эзэмшигч, ТУЗ ба удирдлагын багын ил тод байдал, шийдвэр гаргах үйл явц Монгол улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон холбогдох Монголбанкны дүрэм, журмын дагуу ажиллаж байна.
Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.3 (БАНКНЫ ХАРИЛЦАГЧ, ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ)	ТУЗ ба удирдлагын багийн зүгээс Банкны харилцагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөх үйлдэл, шийдвэр ажиглагдаагүй.
Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.6 (МОНГОЛБАНКИНД ЗӨРЧИЛ МЭДЭЭЛЭХ)	Тэмдэглэхүйц зүйл гараагүй.

4. БУСАД

- (7 дугаар сар, Аудитын хороо) Би хөндлөнгийн аудитортой хийх үйлчилгээний гэрээг батлах тухай асуудалд цахимаар санал өгсөн.
- ЗНДЦУХ-ны гишүүний хувьд, Би Хараат бус гишүүний 1 сул орон тоонд нэр дэвшигчидтэй (8 дугаар сарын 09-ний өдөр нэр дэвшигч А, 8 дугаар сарын 09-ний өдөр нэр дэвшигч Б, 8 дугаар сарын 11-ний өдөр нэр дэвшигч В) хийсэн албан бус ярилцлагад оролцсон.
- 9 дүгээр сарын 05-ны өдөр, I

- 9 дүгээр сарын 15-ны өдөр, Хувьцаа эзэмшигчдийн хурлын өмнө Хараат бус гишүүд хуралдаж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал болон ТУЗ-ийн хурлын асуудлуудыг хэлэлцсэн.
- 9 дүгээр сарын 27-ны өдөр, банкнаас гадуур зохион байгуулагдсан, ТУЗ болон удирдлагуудад зориулсан банкны стратегийн хуралдаанд оролцсон.

Огноо: 2023 оны 10 дугаар сарын 10

Гарын үсэг: Б.Уламбаяр

